



ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН  
ДАРГЫН ТУШААЛ

2019 оны 10 сарын 04 өдөр

Дугаар А/54

Арвайхээр


Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5, аймгийн Засаг даргын 2017 оны а/525 дугаар захирамжаар батлагдсан “Төрийн албан хаагчийн сургалт-хөгжил” дэд хөтөлбөрийн 4.2.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Монгол Улсын Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас 2019 оны 9 дүгээр 27-ны өдөр Булган аймагт зохион байгуулагдах “Төрийн албаны хуулийг хэрэгжүүлэх зарим журам, төвлөрлийг сааруулах бодлогыг хэрэгжүүлэх асуудал” сэдэвт сургалтанд нутгийн захиргааны байгууллагын албан хаагчдыг оролцуулах зардалд 398818 (гурван зуун ерэн найман мянга найман зуун арван найм) төгрөг зарцуулсугай.

2. Дээрх 398818 (гурван зуун ерэн найман мянга найман зуун арван найм) төгрөгийг аймгийн Засаг даргын Тамгын газрын нэмэлт санхүүжилтийн дансны бусдаар гүйцэтгүүлэх бараа, үйлчилгээний зардлаас гаргахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын нягтлан бодогч (О.Цэрэнчимэд)-д зөвшөөрсүгэй.

ДАРГА



Ц.ГАНБОЛД

012100201